

Монгол улсын татвар төлөлтийн төлөвшилтөд татварын зөвлөх үйлчилгээний гүйцэтгэх үүрэг

Илтгэгч: Х.Тунгалагмаа, ТИНБ, МНБ
“МОНГОЛТАКС ТИН” ХХК-ийн ерөнхий захирал

Дэлхий нийтээр даярчлагдан өгжиж буй өнөө үед Монгол улс ч энэхүү хөгжилтэй хамтдаа хөл нийлүүлэн алхсаар байна. Ямар ч улс оронд төрийн зүгээс макро түвшинд эдийн засгийг тогтворжуулах, эдийн засгийн өсөлтийн хурдацыг хангах зарчим ялгаагүй үйлчилдэг. Энэхүү зарчмыг хангахад засгийн газарт шаардлагатай мөнгөний дийлэнх хэсгийг татварын аргаар бий болгодог.

Татвар нь макро үвшинд эдийн засгийн харилцааг зохицуулах үр ашиг бүхий арга хэрэгслүүдийн нэг төдийгүй төрийн мөнгөний нэгдсэн сан бий болгох сонгомол хэлбэрийг өөртөө агуулсан байдаг. Татварын бодлого нь улс орны зайлшгүй хэрэгцээт төсвийн орлогыг бүрдүүлэх, татвар төлөгчдийн үүрэг, татварын ачаалалыг багасгах, цаашдын үйл ажиллагааны хэвийн нөхцлийг хангах, үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт хийх орчинг бүрдүүлэх, татварын албаны бүтэц зохион байгуулалтыг сайжруулах зорилтыг багтааж байдаг.

Аливаа нийгмийн харилцааг зохицуулах явцад албан татварын байр суурь нь түүний чиг үүргээр тодорхойлогддог. Албан татварын чиг үүрэг нь санхүүгийн чиг үүргээ сурган гарч түүний дотор харьцангуй бага хүрээнд үйлчилдэг. Татварын чиг үүрэг нь төрийн оршин тогтнох үндэстэй шууд холбоотой төдийгүй эдийн засгийн мөн чанар, нийгмийн хэрэгцээ, зориулалт, улс орны хөгжил дэвшилд түүхэн үүрэг гүйцэтгэж иржээ.

Улс орны нийгэм, эдийн засаг, улс орны дэглэм өөрчлөгдөж байсан ч төрийн сан хөмрөг бүрдүүлэх үндсэн арга хэрэгсэл болсон албан татвар хуримтлуулалт ажиллагаа өөрчлөгддөггүй билээ.

Төсвийн орлогын голлох эх үүсвэр нь татварын орлого бөгөөд дэлхийн улс орнуудад татвар ногдуулж, хураах “Татвараа өөрөө тодорхойлж төлөх”, “Татварын алба тодорхойлж төлүүлэх” гэсэн 2 систем хэрэглэж байна.

Монгол улсад “Татварын ерөнхий хууль” 1992 онд батлагдаж, хэрэгжиж эхлэснээс хойш 20-иод жилийн турш татвараа өөрөө тодорхойлж, төлөх тогтолцоог хэрэгжүүлсээр өнөөдрийг хүрлээ. Тайлангаар татвараа өөрөө тодорхойлох тогтолцоо нь нэг талаас татвар төлөх ардчилсан үзэл санаанд нийцдэг бөгөөд нөгөө талаас татвар хураалтын төрийн зардлыг багасгах, бага зардлаар их татвар хураах шаардлагад нийцдэг учраас зах зээл өсжсөн болон хөгжиж байгаа орнуудад өргөн хэрэглэгддэг нийтлэг арга болж байна.

Татвараа өөрөө тодорхойлж төлөх аргыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд олон нийтийн татварын талаарх мэдлэг боловсрол өндөр байх, сайн дураараа татварын хууль тогтоомжийг сахих, татварын тайлангаа үнэн зөв гаргаж байх явдал чухал ач холбогдолтой билээ. Энэхүү үйл ажиллагааг өлөвшүүлэхэд татвар төлөлтийн орчин, татварын сургалт, суртчилгаа, татвар

төлөгчдөд үзүүлэх үйлчилгээг боловсронгуй болгох зайлшгүй шаардлага зүй ёсоор урган гарч байна.


Татвар төлөлтийн байдал, түүний хэрэгжилтэнд хийж буй татварын хяналт шалгалтын үр дүнгээс харахад шалгалтанд хамрагдаж буй аж ахуйн нэгж, иргэдийн 65 – 75 хувь нь татварын хууль тогтоомжоо судалж, мэдээгүй, нягтлан бодох бүртгэлийг зөв хөтөлдөггүйгээс болж санамсаргүй гаргасан алдаанаас татварын зөрчилд орж, хүү торгууль төлөн үргүй зардал гаргаж байна. Энэ нь зах зээлийн нийгэмд татварын суурь мэдлэг зайлшгүй болох, түүнчлэн татварын боловсролыг системтэй олгох асуудлыг зүй ёсоор шаардаж байгаа юм.

Татварын албаны гол зорилго нь “Татвар өлөгчид хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ тэгш, шударга, зөв зохистой, бүрэн биелүүлдэг тогтолцоог бий болгох” явдал юм.

Төр татвараар цуглуулсан орлогоор санхүүжиж, мөнгөн хуримтлалыг бүрдүүлэн, түүнийгээ дахин хуваарилах замаар иргэддээ төрийн үйлчилгээг үзүүлдэг. Өөрөөр хэлбэл иргэдээ соёл, боловсролтой болгох, тэдний үүрмэндийг хамгаалах, улс орноо батлан хамгаалах, удирдах, нийгмийн хэм журмыг сахиулах зэргээр төрийн үйлчилгээг үзүүлдэг билээ. Ийм ч учраас Монгол Улсын үндсэн хуульд иргэн хуулиар ногдуулсан албан татвар өлөх үндсэн үүрэгтэй гэж заасан.

Монгол улсын төсвийн орлогын бүтцийг 2009 оны байдлаар авч үзвэл нийт орлогын 81 хувийг татварын орлого эзэлж байна.

График 1.



Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхтгэл 2009

Татварын орлогын бүтцийн дээрх судалгаанаас манай улсын татвар төлөлтийн төлөвшил харагдаж байна. Нийт татварын орлогод нэмэгдсэжүртгийн орлогын албан татварын орлогын 29 хувийг нь эзэлж байна.

Энэ нь дэлхийн улс орнуудын хувьд эдийн засгийн хөгжлийн илтэй улс орнуудад төсвийн нийт орлогод хувь хүний орлогын албан татварын эзлэх хувийн жин өндөр, хөгжиж буй орнуудын хувьд төсвийн нийт орлогод аж ахуйн нэгжийн орлогын албан татварын эзлэх хувийн жин өндөр, буурай хөгжилтэй улс орнуудад төсвийн нийт орлогод нэмэгдсэн өртгийн орлогын албан татварын эзлэх хувийн жин өндөр байдаг бөгөөд буурай хөгжилтэй улс орнуудын хувьд ардмэндээ татварын дарамтыг илүү ихээр үүрүүлдэг гэсэн олон улсын судалгаа байдаг.

Олон улсын татварын үйл ажиллагааны практикт түгээмэл хэрэглэдэг арга нь улс орны эдийн засагт татварын ачааллын (дарамт) хэмжээг макро эдийн засгийн тодорхойлох явдал юм. Татварын ачаалалыг дотоодын нийт бүтээгдэхүүнд татварын орлогын эзлэх хувиар тодорхойлдог. Өөрөөр хэлбэл ($TA = TO/ДНБ$) гэж илэрхийлж болно.

- Төсөвт төвлөрүүлсэн татварын орлогын нийт дүнгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиар
- Цэвэр татвар, хураамжийн орлогын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиар тус тус тооцдог байна.

Монгол улсын татварын ачаалал


Татварын орлого, түүний Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх татварын хувь хэмжээ

Онууд	Татварын ачаалал	ДНБ	Татварын орлого /ТО/
	$TA=TO/ДНБ$		
2004	27%	2 152 094,9	583 119,0
2005	25%	2 779 578,3	692 206,5
2006	30%	3 714 952,9	1 128 140,6
2007	33%	4 599 541,4	1 502 309,9
2008	31%	6 019 838,1	1 890 896,6
2009*	27%	6 055 794,3	1 615 251,2

**Урьдчилсан гүйцэтгэл. Эх сурвалж: Монгол улсын статистикийн эмхтгэл 2004-2009*

Дотоодын нийт бүтээгдэхүүнд татварын орлогын эзлэх хувь хэмжээгээр татварын ачаалалыг тодорхойлов. Дээрх үзүүлэлтийг графикаар дүрслэн харуулъя.

График 2.



2008, 2009 онд татварын ачаалал буурсан үзүүлэлт нь 2007 оны 12 дугаар сарын 31 - нээр татвар төлөгчдөд нэг удаа олгогдсон эдийн засгийн эрх чөлөөтэй холбоотой юм. Энэ нь татварын зарим хууль болон нийгмийн даатгалын хуулийг хэрэгжүүлэх тухай хууль, өршөөлийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор далд эдийн засгийг ил болгож, дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ өссөн гэсэн үг. Гэвч энэхүү боломжийг нийт татвар төлөгчдийн 15 хүрэхгүй хувь нь эдэлсэн байна.

Манай улсын хувьд анх удаа татварын өршөөл үзүүлэх харилцааг зохицуулсан. Энэ үйл ажиллагааг “Татварын зарим хууль болон нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай” хууль болон “Татварын өршөөл үзүүлэх тухай” хууль гэсэн 2 хуулийг дараалан гаргах замаар татварын өршөөлийг үзүүлсэн юм.

Эдгээр хуулийн хэрэгжилтээр татварын хууль тогтоомж зөрчсөн этгээдийг хариуцлагаас 1 удаа чөлөөлсөн нь албан бус хэвшил дэх аж ахуй эрхлэгчдийг хуулийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх нөхцөлийн бүрдүүлэх, далд эдийн засгийг бууруулах, нуугдмал орлого, хөрөнгийг ил болгож эдийн засгийн хууль ёсны эргэлтэд оруулах, татвараас зайлсхийх, татвараа нуух гэмт хэрэг, захиргааны зөрчил багасгах, цаашид татварын орлого нэмэгдэх зорилтуудыг хэрэгжүүлнэ гэж үзсэн байна. Харин өршөөлийн тухай хууль нь татварын хууль тогтоомж зөрчсөн этгээдийг хариуцлагаас 1 удаа чөлөөлсөн харилцааг зохицуулсан болно.

Хуулийн дагуу 7860 татвар төлөгч шинэчилсэн тайлан ирүүлж, 8 төрлийн татвараар 4510,9 тэрбум төгрөгийн орлого, орлогоос бусад ногдох зүйлийг шинээр мэдүүлж, 431,6 тэрбум төгрөгийн албан татвар чөлөөлөгдсөн.

“Татварын өршөөл үзүүлэх тухай” хуулийг 2008 оны 5 дугаар сарын 9-нөөс мөрдөгдөж эхэлсэнээр:

- Хөөн хэлэлцэх хугацаа дууссан 4,0 тэрбум төгрөг
- 10 хувийг төлсний дараа чөлөөлөгдөх 90 хувьд хамрагдах 11,8 тэрбум төгрөг
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэгдэж байсан 8,9 тэрбум төгрөг буюу нийт 28,2 тэрбум төгрөгийн татварын өр, 43 татварын гэмт хэрэг өршөөлд хамрагдсан дүн мэдээ байна.¹

Хэдийгээр энэ хуулиар татвар төлөгчдөд эдийн засгийн эрх чөлөөг нэг удаа эдлүүлсэн боловч татварын өршөөл гэдэг нь татварын албаны болон шударгаар татвараа төлдөг татвар төлөгчдийн сэтгэл зүйд дарамт авчирсан төдийгүй татварын байцаагчаас ихээхэн хүч чармайлт, цаг хугацаа гаргаж илрүүлсэн зөрчил, ногдуулсан нөхөн татвар, хүү, торгууль нь хүчингүй болсноор татвар төлөгчийн өмнө буруутай мэт байдал бий болгож цаашид идэвхтэй ажиллах эрмэлзлийг нь мохоодог. Татварын алба ч татвараа хуулийн дагуу хураан барагдуулах чадваргүй байгууллага мэт ойлгогдоод зогсохгүй, татвар төлөгчдөд ч хүлээлт бий болгох зэрэг сөрөг үр дагавар ажиглагдсан болно.

2009 оны жилийн эцэст татварын тайлангийн ирц 88 хувьтай, үүнээс “Х” тайлан гаргасан нь 35 хувь байснаа 2010 оны хоёрдугаар улиралд татварын тайлангийн ирц 85 хувьтай, үүнээс “Х” тайлан гаргасан нь 46 хувь болж өссөн байна. Дээрх тоон үзүүлэлтээс Монгол улсын татвар төлөлтийн төлөвшилт хангалтгүй байна гэсэн дүгнэлтэнд хүргэж байна.²

Монгол улсад татвар өлөлтийн төлөвшилтийг сайжруулах үндэс нь зөв бүртгэлийг хөтлөх, бэлэн мөнгөний гүйлгээг хязгаарлах, мэдээллийн сүлжээг үүсгэх явдал юм. Энэ ажлын хүрээнд нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн болон татварын тайлан гаргалт, технологийн шийдлийн чанарыг сайжруулснаар татварын орлого мэдээ нэмэгдэх чухал нөхцөл болдог. Санхүүгийн тайлан гаргалт түүнд мэргэшсэн мэргэжилтнүүдийн хянаж шалгах, баталгаажуулах, татварын талаарх өвлөлгөө мэдээлэл өгч чаддаг бүтцийг хөгжүүлэн ажиллах нь татварын өвлөх үйлчилгээ, нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээний й мэргэшсэн ажлынүр дүн болж гарах учиртай.

Монгол улсад татварын өвлөх үйлчилгээний салбар хөгжөөд удаагүй төдийгүй хөгжингүй улс орнуудын түвшинд хүрэхэд харьцангуй төлөвших хугацаа шаардагдсаар байна. Одоогийн байдлаар татварын өвлөх үйлчилгээ нь татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч зөвлөхүүдийн “ТИНЗ” нийгэмлэг түүний гишүүн байгууллагууд болох “ТАКС ТИН” компаниудаар дамжин татвар төлөгчдөд хүрч байна.

Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн систем нь татварын тэгш шударга, ил тод байх зарчимд харшилсан албан бус сектор буюу далд эдийн засгийг ил гаргах, нийгмийн үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэгдэж, энэхүү шинж чанараараа төсвийн орлогыг бүрдүүлэхэд гүйцэтгэж буй үүрэг, татварын бодлогын удирдлага,

¹ Татварын ерөнхий газрын мэдээллийн бааз

² <http://www.mta.mn>

төлөвлөлтийг боловсронгуй болгоход оруулж буй хувь нэмрийг дараах судалгаагаар илэрхийлэхийг зорилоо.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний хэрэгцээ, шаардлага өсөхийн хирээр тэдний үүрэг хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг тодорхойлох үднээс макро, мезо, микро орчинд судалгаа хийсэн үр дүнг нэгтгэн дүгнээд судалгааны хамрах хүрээ, үр дүнг доорхи загварт нэгтгэн харуулав.



Энэхүү макро, мезо, микро орчны түвшинд хийсэн судалгааг тоон болон чанарын аргаар гүйцэтгэсэн болно. Судалгааг асуулгын болон анкетын аргаар нээлттэй хэлбэрээр авсан бөгөөд судалгаанд оролцогчдыг санамсаргүй түүврээр сонгосон. Судалгааны мэдээллийг Улаанбаатар хотын Үхбаатар, Баянзүрх, Баянгол дүүргүүдийн аж ахуйн нэгж байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, тус дүүргүүдийн татварын хэлтсийн ажилтнууд, төрийн албан хаагч, мэргэжлийн болон мэргэшсэн, итгэмжлэгдсэн нягтлан бодогч нараас санал асуулгын аргаар авсан билээ.

Судалгааны зорилго нь Монгол улсад татварын итгэмжлэгдсэн үйлчилгээний нийгмийн хэрэгцээ үүсч байгаа, түүнд ямар үүрэг тэй оролцон ажиллаж байгаа, татварын хууль тогтоомжуудын хэрэгжилтийг бүрэн ханган ажиллах үүднээс мэргэшсэн зөвлөх үйлчилгээний үйл ажиллагаанд дүгнэлт өгөх, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход чиглэв.


Судалгааны хамрах хүрээ:

Судалгаа нэг	Макро орчин	Бодлого хууль эрх зүйн орчны судалгаа (Өөрчлөлт шинэчлэлтийн байдал)
Судалгаа хоёр	Мезо орчин	<ul style="list-style-type: none"> • Татварын алба, төрийн алба хаагчид • Татварын зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байгууллагын боловсон хүчин ТИНБ, МНБ -доос авсан судалгаа
Судалгаа гурав	Микро орчин	Татвар төлөгч аж ахуйн нэгж, хувь хүн иргэдээс авсан судалгаа

Мэдээллийн чанар логик уялдаа, хариултын боломжит хувилбарыг шалгах, тандах зорилгоор туршилтын судалгааг 2009 оны 9-н сард авсан бол давтан судалгааг 2010 оны 9 сарын эхээр авсан болно.

Бидний туршилтын судалгааныгүндсэн дээр санал асуулгын хуудсанд өөрчлөлт оруулж дахин засварласан хувилбараар санал асуулгыг авсан.


Судалгаа нэг. Макро орчин Татварын эрх зүйн орчин



Монгол Улсын олон улсын гэрээнд Монгол Улсын татварын хууль тогтоомжоо өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө. (ТЕХ-2.2)

Татварыг эвхэн Улсын Их Хурал хуулиар бий болгох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй (ТЕХ-3.1) гэсэн байдаг.

Хууль зүйн хувьд: (Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль)



Шинэчилсэн найруулгаар батлагдсан Татварын ерөнхий хуулийн үзэл баримтлал

Татварын ерөнхий хуулийн зорилт нь:

“Монгол Улсад татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах эрх үйн үндсийг тогтоож, татвар төлөгч болон татварын албаны эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.”

Татварын хуулийн үйлчлэх хүрээ:

- чөлөөт бүсэд мөрдөх тусгай дэглэм тогтоох,
- тогтвортой байдлын болон эсхүл хөрөнгө оруулалтын гэрээгээр, уг гэрээг байгуулах үед мөрдөж байсан татварын нөхцлийг хадгалах дэглэм тогтоохоос бусад бүх тохиолдолд татвар бий болгох, өөрчлөх, чөлөөлөх, хөнгөлөх, ногдуулах харилцааг зөвхөн татварын хуулиар зохицуулахаар хуульчилсан
- Татвар төлөгчийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн
 - ✓ Татвар төлөгчийг тодорхойлж, бүртгэх харилцааг зохицуулж өгсөн
 - ✓ Татвар төлөгчийн эрхийг өргөтгөж, хуулиар ногдсон татвараа өөрөө тодорхойлон төлөхтэй холбогдон үүсэх үүргийг тодотгон заасан
 - ✓ Татварын хууль тогтоомж эрчсэн татвар төлөгчид хүлээлгэх хариуцлагыг зөрчлийн хэлбэрээс хамааран ялгамжтай тогтоосон
 - ✓ Татварын албанаас татвар төлөгчдөд үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг, татвар төлөгчийн хууль ёсны ашигсонирхолыг хүндэтгэн ажиллах зарчмыг хуульчилсан.
- Татвар төлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх

- ✓ Татвар төлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэж, тэдэнд итгэлүзүүлэн ажиллана
 - ✓ Татвар хураахтай холбоотойгоос бусад асуудлаар татвар өлөгчийн үйл ажиллагаанд оролцохыг хориглоно
 - ✓ Татвар төлөгчийн нууцыг хадгална.
- Татвар төлөгчид мэргэжлийн зөвлөлгөө өгөх
- ✓ Татвар төлөгчид хууль тогтоомжоор тодор хойлсон татвар өлөх үүргээ биелүүлэх, эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах талаар мэргэшиж, бүртгэгдсэн зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх харилцааг хуулиар зохицуулна
 - ✓ Татварын албанүйл ажиллагааг боловсронгуй болгох зорилго бүхий зохицуулалтыг оруулсан
 - ✓ Татварын хяналт шалгалттай холбоотой харилцаа, ялангуяа оролцогч талуудын эрх үүрэг, баримтлах зарчим, татварын хяналт шалгалт хийх үндэслэл зэргийг хуульчилсан
 - ✓ Татварын улсын байцаагч, татварын алба буруу шийдвэр гаргасноохаа т хариуцлага хүлээх асуудлыг нарийвчлан зохицуулсан.

Судалгаа хоёр. Мезо орчин

Судалгаанд Сүхбаатар, Баянзүрх, Баянгол дүүргийн татварын албаны болон төрийн 120 албан хаагчид, татварын өвлөх үйлчилгээ үзүүлдэг байгууллагын боловсон хүчин, татварын итгэмжлэгдсэн болон мэргэшсэн нягтлан бодогч 180 хүн хамрагдсан бөгөөд тэдний 70 хувь нь эмэгтэй, 30 хувь нь эрэгтэй, насны бүтцийн хувьд 25 нас хүртэлх нь 7,6 хувь 25 - аас 40 насных нь 53,8 хувь, 40 - өөс 55 насных нь 38,6 хувь байв.

Судалгааны зарим нэг дүнгээс харуулбал:

Та татвараа өөрөө тодорхойлон төлөх, тайлагнах үүргийн төлөвшил ямар түвшинд байна гэж үзэж байна вэ? гэсэн асуултанд татвараа өлөх төлөвшлийг 73% буюу дунд зэрэг гэсэн хариултыг өгсөн байна.

Та татвар өлөгчидтэй учрах эрсдлийг бууруулахад татварын өвлөх, итгэмжлэгдсэн үйл ажиллагааны үүрэг ямар байна гэж үзэж байна вэ? гэсэн асуултанд дээрх судалгаанд хамрагдсан татварын улсын байцаагч, төрийн албанд ажиллагчид 46 хувь нь нэнчухал, 3 хувь нь шаардлагатай, 23 хувь нь чухал гэж хариулснаасүзэх эд татварын зөвлөх итгэмжлэгдсэн үйл ажиллагааны хэрэгцээ, үүрэг ролийг тодорхойлж байна.

Таны хувьд татвар төлөгч татвараа сайн дураараа тодорхойлон төлөх төлөвшлийг бүрдүүлэхийн тулд ямар үйл ажиллагаа явуулах нь илүүүр дүнтэй гэж үзэж байна вэ? гэсэн асуултанд

- ✓ Татварын хууль, журмыг сурталчилах, таниулах, хууль үйлжзорчныг тогтвортой болгох, татвар ногдуулалт, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар сурталчилах
- ✓ Иргэдийн оролцоог дэмжих, идэвхитэй болгох, өрөөс дэмжих, татварын орлого нь улс эх орны сайн сайхнылөө зарцуулагддаг гэдгийг ойлгуулах, татвар төлсний ач холбогдлыг ухуулах
- ✓ Татварын боловсролыг сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт оруулах
- ✓ Туслалцаа зөвлөгөө өгөх төвүүдийг шинээр бий болгох
- ✓ Татвар төлөгчийг урамшуулах системийг боловсронгуй болгох


- ✓ Бэлэн мөнгөний гүйлгээг багасгаж, зээлийн картын системийг бүх салбарт хэрэглэх зэрэг гэж хариулсан байна.

Судалгаа гурав. Микро орчин

Энэхүү судалгааг бизнесийн үйл ажиллагаа явуулж буй жижиг дунд бизнес эрхлэгчид, хувь хүн, хувиараа бизнес эрхлэгчдээс санамсаргүй түүврийн аргыг ашиглан судалсан. Нийт 200 хүн сонгон, тэднээс асуулгын аргыг ашиглан авсан болно. Тэдний 44 хувь нь хувиараа бизнес эрхлэгч иргэд, 56 хувь нь аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл байв.


Судалгааны зарим дүнг тодруулбал:

Таны хувьд Монгол улсын татварын ачаалал хэр түвшинд байна вэ? гэсэн асуултанд 40 хувь нь дундаж, 37 хувь нь их, 11 хувь нь маш их, 9 хувь нь бага, 3 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.




Татвартай холбоотой тайлан тооцоогоо хэрхэн хийж, тайлагнадаг вэ? Гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 44 хувь нь нягтлан бодогчоороо, 23 хувь нь болон танил талаараа, 33 хувь нь аудит, сүүлийн зөвлөгөө өгдөг байгууллага болон татварын итгэмжлэгдсэн байгууллагаар гэж хариулсан байна. Тэдний хувьд татварын хяналт шалгалтанд хамрагдалт 72 хувь байсан.

Танд /танай байгууллагад/ татварын хяналт шалгалтаар ямар нэгэн өрчил илэрч байсан уу ? гэсэн судалгааны асуултанд татварын хяналт шалгалтанд хамрагдаж байсан татвар т лөгчид дараах байдлаар хариулсан.



Та үүнээс хойш татварын болзошгүй эрсдлээс болгоомжлох тал дээр мэргэжлийн зөвлөлгөө туслалцаа авахыг илүүд үзэх болсон уу? асуултанд дараах байдлаар хариулжээ.



Энэхүү судалгаагаар Монгол улсад татварын итгэмжлэгдсэн үйлчилгээний нийгмийн хэрэгцээ, шаардлага, үйцэтгэх үүрэг, татварын хууль тогтоомжуудын хэрэгжилтийг бүрэн хангах үндсэн зорилго, үйл ажиллагааныхаа хүрээнд дүгнэлт өгч, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлохыг зорьсон билээ.

Цаашид Монгол улсын татвар төлөгчдийн татвараа өөрөө тодорхойлж, төлөх тогтолцооны төлөвшил улам бүр сайжирч, улмаар улс орныхоо хөгжил дэвшилд оруулах хувь нэмрээ ухамсарлан татварын төлөх үйлчилгээний давуу талыг мэдэрч, татварын эрсдлээ бууруулан хамгийн чухал нь “татвараа өлөх” гэсэн сэтгэхүйг иргэн, татвар төлөгч бүрт төлөвшүүлж, үндсэн хуулиар ногдсон үүргээ нэр төртэй хэрэгжүүлэх нь тэдний бахархал байхыг ойлгуулан хэрэгжүүлж, татварын алба, татвар төлөгчдийг холбох нь мэргэшсэн зөвлөх үйлчилгээний эрхэм зорилго байх болно.

Энэ ажлын үрээнд бид үйл ажиллагаа эрхэлсэн богинохон хугацаандаа иргэний нийгмийн татварын боловсрол олгох асуудлыг өөрийн компанийн нийгмийн хариуцлагын гол цөм болгон ажиллаж байна.

2007 оноос эхлэн татварын өтөч 1, 2, 3, 4, 5 цувр ал, 2009 онд эх орны ирээдүйн эзэд болсон хүүхдүүдэд татвар төлөх сэтгэлзүйн төлөвшлийг зөв олгох зорилгоор өөрийн байгууллагын ажилтнуудын үжээр Улаанбаатар хотын 8, Булган, Дархан, Хэнтий, Төв, Өмнөговь аймгийн ерөнхий боловсролын сургуулийн нийт 2800 хүүхдэд “Татвар бидний амьдралд” 6 цагийн хичээл зааж, уг хичээлийн агуулгыг бататгах зорилгоор “Тэм хүүгийн татвартай танилцсан түүх” 3 цуврал комик номыг хэвлүүлэн гаргаж олон нийтийн хүртээл болгоод байна.

Мөн цаашид нэн яаралтай дараах асуудалд анхаарлаа хандуулах нь зүйтэй байна. Үүнд:

- Татварын бодлого, хууль эрх орчны судалгаа хийж, цаашид ямар арга замаар хүндрэл бэрхшээл, тулгарч буй асуудлуудыг зөв шийдэх гарцыг бодлогын түвшинд шийдвэрлүүлэх боломжит шийдлүүдийг дэвшүүлэн гаргах
- Нягтлан бодох бүртгэлийн “outsourcing”, татварын өвлөх үйлчилгээний хэрэгцээ үүсч, энэ төрлийн үйлчилгээний зорилтот зах зээлийн хүрээг судлах
- Татварын мэргэшсэн өвлөх үйлчилгээний зорилтот зах зээл болох хувиараа а бизнес эрхлэгч, жижиг дунд бизнес эрхлэгчид, иргэдээс эхлэн хуулийг таниулан сурталчилах, тэдний татварын боловсролыг тасралтгүй дээшлүүлэх

Таны төлсөн татвар хөгжлийн хурдасгуур

Ашигласан эх сурвалжууд:

1. Үндэсний Татварын ерөнхий газар, Татварын тогтолцоо, Тэргүүн дэвтэр, УБ, 2002
2. Үндэсний Татварын ерөнхий газар, Татварын тогтолцоо, Дэд дэвтэр, УБ, 2002
3. С.Баатар, Я.Пүрэвээ, Б.Ганхүлэг, Татварын онол, арга зүйн зарим асуудлууд, УБ, 1997
4. Монгол Улсын статистикийн эмхтгэл, УБ 2004-2009
5. Татварын ерөнхий газар, Монгол улсын их сургуулийн Хууль Зүйн сургууль, Шинжлэх Ухааны академийн философи, социологи, эрх зүйн зүрээлэн Монгол улсын албан татварын эрх зүй, УБ, 2009
6. МУХЗДХЯ, Хууль зүйн үндэсний төв, Татвар төлөгчдөд зориулсан эрх зүйн баримт бичгийн эмхтгэл, УБ, 2008
7. Монгол Улсын татварын ерөнхий хууль. 2008
8. <http://www.nso.mn>
9. <http://www.legalinfo.mn>
10. <http://www.mta.mn>
11. <http://www.pmis.gov.mn>
12. <http://www.worldbank.org>
13. <http://www.heritage.org.gov.mn>
14. <http://www.taxpolicycenter.org>
15. <http://en.wikipedia.org>
16. <http://www.investmongolia.com>